

НАЙМ. 4G LTE БОЛОН 3G СҮЛЖЭЭНД ДАТА АШИГЛАХ

- 8.1 Хэрэглэгчийн дугаар ашиглаж байгаа байршлаас шалтгаалж дата хэрэглээ 3G болон 4G LTE сүлжээнд ашиглагдана.
- 8.2 Багцын дагалдах дата дуусмагц задгай хэрэглээгээр тооцох ба тухайн байршлын сүлжээгээр ашиглана.
- 8.3 4G LTE дата багцтай ч сүлжээний хамрах хүрэнээс гарсан тохиолдолд 3G сүлжээ рүү шилжиж ажиллана.
- 8.4 Нэмэлт дата багцыг 3G болон 4G LTE сүлжээнд ашиглах боломжтой.
- 8.5 Нэмэлт дата багцыг сарын аль ч хугацаанд идэвхжүүлсэн тухайн сарыг дуустал ашиглах хугацаатай байх ба багцаас хэтэрсэн хэрэглээ задгай тарифаар тооцогдоно.
- 8.6 Задгай датаны хэрэглээ хийхэд хэрэглэгчийн аль сүлжээнд (3G болон 4G LTE) байгаагаас хамааран ажиллах ба тариф ижилхэн байна.
- 8.7 Нэмэлтээр авсан дата багцын төлбөр хэрэглээний төлбөртэй хамт нэхэмжлэгдэнэ.

ЕС. ҮЙЛЧИЛГЭЭГ ЗОГСООХ, ХЭРЭГЛЭГЧИЙН ХҮСЭЛТЭЭР ГЭРЭЭГ ЦУЦЛАХ

- 9.1 Тухайн сарын хэрэглээний төлбөрийг дараа сарын 20-ний дотор төлөөгүй тохиолдолд сарын сүүлийн өдөр хүртэл гарах үйлчилгээний эрхийг зогсоож, орох үйлчилгээний эрхийг хэвээр үлдээх бөгөөд сарын сүүлийн өдөр орох, гарах үйлчилгээний эрхийг төлбөр төлөх өдөр хүртэл зогсооно.
- 9.2 Хэрэглэгч өөрийн хүсэлтээр гэрээг цуцлах тохиолдолд үйлчилгээний төвд өөрийн биеэр цахим үнэмлэх эсвэл хурууны хээ уншигчийн мэдээллийг үндэслэн дараах төлбөрүүдийг төлж барагдуулан үйлчилгээг зогсооно. Үүнд:
 - Гэрээг цуцлах хүртэлх хугацаанд ашигласан үйлчилгээний нийт төлбөр;
 - Бусад төлбөрүүд
- 9.3 Хэрэглэгч гэрээ цуцлах хүсэлтээ албан ёсоор мэдэгдээгүй болон дугаар хадгалуулах үйлчилгээ аваагүй тохиолдолд тухайн дугаарыг төлбөрийн улмаас идэвхгүй төлөвт шилжсэнээс хойш 181 дэх хоногт барьцаа төлбөрөөс хэрэглээний нийт төлбөрийг суутгах ба барьцаа төлбөрөөс хэтэрсэн үлдэгдэл төлбөрийг хэрэглэгч бүрэн хариуцан барагдуулна.

АРАВ. БУСАД

Энэхүү дараа төлбөрт үйлчилгээний нөхцөлд шүүд заагаагүй, тусгагдаагүй бусад үйлчилгээний нөхцөлийг тухайн үед Скайтел ХХК-ийн Хэрэглэгчид үзүүлж буй үйлчилгээний нөхцөлөөр зохицуулагдах ба Дараа төлбөрт үйлчилгээний нөхцөлд Скайтел ХХК дангаараа өөрчлөлт оруулах эрхтэй.